



ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2021-2025)”-ийн төслийг боловсруулсан тухай

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь албан ёсны статистик (АЁС)-ийн үзүүлэлтийг тооцох, тооллого, судалгаа явуулах талаар ойрын зорилтыг тодорхойлсон хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулах” гэсэн заалтыг үндэслэн Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулж, хэрэгжүүлдэг. ҮСХ нь Статистикийн салбарыг 2006-2010, 2011-2015, 2017-2020 онд хөгжүүлэх гурван удаагийн хөтөлбөрийг боловсруулж, УИХ-аар батлуулан, хэрэгжүүлсэн.

Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг тухайн улсын статистикийн байгууллагын төдийгүй үндэсний статистикийн системд хамаарах төрийн бусад байгууллагуудын хөгжлийн хамтын баримт бичиг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, энэ хөтөлбөр нь статистикийн байгууллагын үйл ажиллагаа, үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэх, зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж, түүнд хүрэх арга зам, шаардагдах хөрөнгө, хүн хүчний нөөцийг нарийвчлан тооцсон дэс дараатай хэрэгжүүлэх тулгуур баримт бичиг юм.

Тус хороо нь статистикийн салбарыг 2021-2025 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд хөтөлбөрийн төслийн зорилго, зорилт, үйл ажиллагааны хүрээг дараах бүтэц, агуулгатайгаар бэлтгээд байна.

Статистикийн салбарын стратегийн зорилго нь шинжлэх ухааны үндэслэлтэй, өндөр чанартай статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг хангахад оршино.

Зорилт	Төлөвлөж буй үйл ажиллагааны тоо
1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2
2. Хүний нөөцийн хөгжлийг хангах	2
3. Дэд бүтцийг сайжруулах (статистикийн болон техник технологийн)	3
4. Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох	17



“МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН САЛБАРЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ийн төсөл

Нэг. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт нь төрийн болон хувийн байгууллагуудад үүссэн мэдээллийн санг авч ашиглах харилцааг зохицуулах, анхдагч мэдээлэл бүхий сангийн аюулгүй байдал, эзэмшил ашиглалт, бусадтай хуваалцах, ашиглуулах харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг хангахад чиглэнэ.

1.1.1. Олон улсын цогц үнэлгээний зөвлөмж, сайн туршлагад үндэслэн статистикийн бие даасан, хараат бус байдал, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах өөрчлөлтийг Статистикийн тухай хуульд нэмж оруулах.

1.1.2. Статистикийн тухай хуулийн дагуу үйл ажиллагааг зохицуулах журам, дүрмийг боловсронгуй болгож шинэчлэх.

1.2. Хүний нөөцийн хөгжлийг хангах зорилт нь статистикийн мэргэшсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

1.2.1. Үндэсний статистикийн системд хамаарах байгууллагуудын ажилтнуудыг системтэйгээр сургах сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтын төвийг байгуулж ажиллах.

1.2.2. Статистикийн салбарын албан хаагчдын нийгмийн асуудал, ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллыг төрийн захиргааны төв байгууллагуудтай дүйцэх хэмжээнд хүргэх.

1.3. Дэд бүтцийг сайжруулах зорилт нь статистикийн болон техник технологийн дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээллийн санг холбох, компьютер тоног төхөөрөмж, дагалдах программ хангамжийг сайжруулахад чиглэнэ.

1.3.1. Нэгдсэн стандарт, аргачлал, ангилал кодын нэвтрэлт, статистикийн бүртгэлийг сайжруулах.

1.3.2. Холбогдох төрийн байгууллагуудтай хамтран мэдээллийн сангуудын чанар, системийг үнэлэх, холбох.

1.3.3. Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах:

1.3.3.1. Статистикийн дата төвийн хүчин чадлыг сайжруулах.

1.3.3.2. Нөөц дата төв байгуулах.



1.3.3.3. Албан ёсны лицензтэй мэргэжлийн болон хэрэглээний программуудыг ашиглах.

1.3.3.4. Орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх (таблет, дрон, хиймэл дагуулын зураг).

1.3.3.5. Утсаар мэдээлэл цуглуулах төв (Call center)-ийг өргөжүүлэх.

1.4. Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох зорилт нь статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үндэсний статистикийн системийг хөгжүүлэхэд чиглэнэ.

1.4.1. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.

1.4.2. Төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн санг албан ёсны статистикийн мэдээллийг гаргах, шалгах, уялдуулахад ашиглах.

1.4.3. Албан ёсны статистикийн үйл ажиллагааны бүх үе шатанд газарзүйн мэдээллийн системийн ашиглалтыг нэмэгдүүлэх.

1.4.4. Их өгөгдлийг албан ёсны статистикийн мэдээллийг гаргахад ашиглах.

1.4.5. Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох, өргөжүүлэх.

1.4.6. Статистикийн хэрэглэгчид, ялангуяа бизнес эрхлэгчдийн мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай мэдээллийг бий болгох.

1.4.7. Монгол Улсын Статистикийн тухай хуульд зааснаас гадна холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах судалгаа явуулах. Үүнд:

1.4.7.1. Бичил уурхай судалгаа;

1.4.7.2. Бизнес регистрийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулах судалгаа;

1.4.7.3. Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа;

1.4.7.4. Ногоон ажлын байрны судалгаа;

1.4.7.5. Гэмт хэргийн хохирогчийн судалгаа;

1.4.7.6. Жендерт суурилсан хүчирхийллийн судалгаа;

1.4.7.7. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа;

1.4.7.8. Бизнесийн хандлага, орчны судалгаа;

1.4.7.9. Хүнсний алдагдлын судалгаа;

1.4.7.10. Далд эдийн засгийн судалгаа;

1.4.7.11. Гадаад худалдааны үнийн судалгаа;

1.4.7.12. Орон сууцны үнийн судалгаа.



- 1.4.8. Захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн сангуудыг ашиглан мэдээллийг богино давтамжаар тооцох.
 - 1.4.9. Нийгэм, эдийн засаг, байгаль орчны үзэгдлүүдийн өөрчлөлт, үялдаа холбоо, харилцан хамаарал, нөлөөллийн шинжилгээ, гүнзгийрүүлсэн, сэдэвчилсэн судалгааны ажлыг өргөжүүлэх.
 - 1.4.10. Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор статистикийн чанарын удирдлагын системийг нэвтрүүлэх.
 - 1.4.11. Статистикийн мета мэдээллийн санг олон улсын байгууллагын үнэлгээний үзүүлэлтийн дагуу баяжуулж, тархаах.
 - 1.4.12. Түүврийг олон улсын арга зүйд нийцүүлэн хөгжүүлж, судалгааны түүврийн хэмжээг нэмэгдүүлж, засаг захиргааны нэгжийн түвшинд мэдээллийг гаргах боломжийг бүрдүүлэх.
 - 1.4.13. Хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн мэдээллийг оновчтой арга хэрэгслээр тухайн цаг хугацаанд нь хүргэх.
 - 1.4.14. Статистикийн мэдээллийн нэгдсэн санг сайжруулах.
 - 1.4.15. Хэрэглэгчдэд зориулсан статистикийн сургалтыг өргөжүүлэх.
 - 1.4.16. Үндэсний хэмжээнд байгууллага хоорондын мэдээллийн үялдааг сайжруулахад чиглэсэн хамтын ажиллагааг бэхжүүлэх.
 - 1.4.17. Олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын статистикийн нийгэмлэгт эзлэх байр суурь, нэр хүндийг өсгөх, төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг сайжруулах, статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэх.
Хоёр: Энэ хөтөлбөрт заасан зорилтуудыг хэрэгжүүлснээр гарах үр дүн
- 2.1. Энэ хөтөлбөрийн 1.1-д заасан зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ.
 - 2.1.1. Албан ёсны статистикийн үйл ажиллагаа, ялангуяа хүний нөөцийн, санхүүгийн, техник технологийн, арга зүйн бие даасан, хараат бус байдлыг улам бэхэжнэ.
 - 2.1.2. Төрийн болон хувийн байгууллагуудын мэдээллийн санг ашиглах, нууцлалыг хангасан статистикийн мэдээллийн санг ашиглуулах, сангуудаа үялдуулах, холбох эрхтэй болно.
 - 2.2. Энэ хөтөлбөрийн 1.2-д заасан зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ.



- 2.2.1. Үндэсний статистикийн системд хамаарах байгууллагуудын ажилтнуудыг системтэйгээр сургах, тэдний статистикийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, ажилтнуудын тогтвор суурьшлыг хангаж, мэдээллийн чанар улам сайжруулах нөхцөл бүрдэх.
- 2.2.2. Статистикийн салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаснаар ажилтнуудын сэтгэл ханамж, бүтээмжийг дээшлүүлэх.
- 2.3. Энэ хөтөлбөрийн 1.3-д заасан зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ.
 - 2.3.1. Үндэсний статистикийн системд нэгдсэн стандарт, ангилал код, аргачлалыг нэвтрүүлэх үйл ажиллагаа хууль эрх зүйн хүрээнд шуурхай хэрэгжинэ.
 - 2.3.2. Төрийн мэдээллийн нэгдсэн санг байгуулах, уялдуулах, сангуудыг харилцан ашиглах, мэдээллийн зөрүүтэй байдал арилна. Төрийн байгууллагуудад үүсэж байгаа мэдээллийн сангуудыг бүртгэж, чанарыг үнэлж, шаардлага хангасан мэдээллийн сангуудыг холбож, статистикийн зорилгоор ашиглана.
 - 2.3.3. Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:
 - 2.3.3.1. Одоо байгаа статистикийн дата төвийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх;
 - 2.3.3.2. Нөөц дата төв байгуулснаар мэдээллийн аюулгүй хангагдах;
 - 2.3.3.3. Албан ёсны лицензтэй мэргэжлийн болон хэрэглээний программуудыг ашигласнаар мэдээллийн аюулгүй байдал сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэх;
 - 2.3.3.4. Мэдээлэл цуглуулах орчин үеийн техник, технологи нэвтрүүлж, мэдээллийг шуурхай цуглуулах, нэгтгэх, зардал хүн хүч хэмнэх боломж бүрдэх.
- 2.4. Энэ хөтөлбөрийн 1.4-д заасан зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ.
 - 2.4.1. Статистикийн мэдээллийг эрхлэн гаргах технологийн үе шат боловсронгуй болж, одоо байгаа төлөвшлийн үе шатыг ахиулж, 4-р үе шатанд буюу байгууллагын хэмжээний нэвтрэлтийн үе шатанд хүргэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
 - 2.4.2. Статистикийн чанарын удирдлагын систем нэвтэрч, ISO-9001 стандартын дагуу бодлогын баримт бичгүүд шинэчлэгдэж, хэрэгжилтийг хангана.
 - 2.4.3. Дэлхийн болон үндэсний Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох, холбогдох талуудтай хамтран ажиллаж тооцох боломжгүй байгаа үзүүлэлтүүдийн эх үүсвэр тодорхой болно.
 - 2.4.4. Бизнес эрхлэгчдэд болон бусад хэрэглэгчдэд хэрэгцээтэй тоо мэдээллийг тодорхойлж, шаардлагатай тоо мэдээллээр хангах боломжтой болно.
 - 2.4.5. Их өгөгдлийг албан ёсны статистикийн зорилгоор ашиглах, уялдуулах боломж бүрдэнэ.



- 2.4.6. Судалгааны түүврийн дизайныг сайжруулж, түүврийн хэмжээг нэмэгдүүлснээр үр дүнг засаг захиргааны бага нэгжийн түвшинд гаргах төлөөлөх чадвар сайжрах.
- 2.4.7. Үндэсний түвшинд байгууллага хоорондын мэдээллийн уялдаа сайжирч, арга зүйн нэгдмэл байдал хангагдаж, мэдээллийн чанар сайжирна.
- 2.4.8. Мета мэдээллийн сан сайжирч, мэдээллийн нээлттэй байдал, хэрэглэгчдийн статистикийн байгууллагад итгэх итгэл нэмэгдэнэ.
- 2.4.9. Олон талт болон хоёр талт хамтын ажиллагаа өргөжсөнөөр олон улсын статистикийн нийгэмлэгт эзлэх байр суурь, нэр хүнд өсөж, төсөл хөтөлбөрийн үр өгөөж дээшилж, статистикийн салбарын чадавх бэхэжнэ.
- 2.4.10. Мэдээлэл тархаалтын шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлснээр статистикийн хэрэгцээт мэдээллийг тухайн цаг хугацаанд нь шүүрхай хүргэж, албан ёсны статистикийн хэрэглээ нэмэгдэнэ.
- 2.4.11. Статистикийн судалгаа шинжилгээний ажил өргөжиж, мэдээллийн чанар, уялдаа сайжирч, хэрэглэгчид олон төрлийн мэдээллээр хангагдана.

---oOo---